

**МАХН-ЫН XVIII ИХ ХУРАЛ, ДОРНОДАХИНЫ
СУДЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ****Р. Рэнчин**

МАХН-ын XVIII их хурал манай оронд социализм байгуулах таатай гадаад нөхцөлийг хангахад онцгой анхаарал тавьсан юм. Энэ нөхцөлийн баталгаа болсон Монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдал бүх талын хамтын ажиллагааг юуны өмнө хэлбэрэлтгүй бэхжүүлэн гүнзгийрүүлэх, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хоорондын улс, төр, эдийн засаг, үзэл суртлын хамтын ажиллагааг улам бэхжүүлэх явдлыг манай намын нэн тэргүүн зорилт болгон дэвшүүлэв.

Социалист хамтын нөхөрлөлийн орнуудын ард түмний уламжлалт найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх үйлсэд жил бүр болдог социалист орнуудын коммунист, ажилчны намуудын удирдагчдын Крымын уулзалт чухал ач холбогдолтой байдгийг ЗХУКН-ын XXVI, МАХН-ын XVIII их хурлууд онцлон тэмдэглэсэн билээ. Энэ онд болж өнгөрсөн нөхөр Л.И. Брежнев, Ю. Цэдэнбал нарын уулзалт олон улсын байдлыг эрүүлжүүлэх, намжмал байдлын явцыг гүнзгийрүүлэх, дэлхийн дайны аюулыг зайлуулах, түүний дотроос Азийн аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой анхаарал тавив.

Ах дүү намуудын хоорондын нягт хамтын ажиллагаа, нэгдмэл байр суурь нь олон улсын хүнд байдлыг намжаах, цөмийн дайны хөнөөлөөс хүн төрөлхтнийг аврах үндсэн баталгаа болж байгаа учраас манай намуудын удирдагчдын уулзалтад монголын ард түмэн чин сэтгэлийн талархал дэвшүүлж байдаг юм.

Дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад ЗХУКН-ын XXVI их хурлаас дэвшүүлсэн Зөвлөлтийн наяд оны энх тайвны программыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх явдал дэлхийн социалист систем, нийт дэвшилт хүчний тэргүүн зорилт болж байна. Учир нь олон улсын империализм, түүнийг аялдан дагалдагчид «зөвлөлтийн аюул» гэгч зохиомол зүйл гаргаж дайсагнасан ажиллагааныхаа үзүүрийг ЗХУ, социализмын бусад орон, нийт дэвшилт хүчний эсрэг чиглүүлж байна.

БНМАУ Азийн анхны социалист орны хувьд Ази тивийн хурцадмал байдлыг намжаах, тус тивийн орнуудын итгэлцлийг бэхжүүлэх, Ази, Номхон далайн районы энх тайван аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн аливаа санаачлагыг дэмждэг бөгөөд түүнд өөрийн хувь нэмрээ оруулах явдлыг ариун үүргээ гэж үздэг юм.

Ази тивийн байдлыг тогтворжуулах, энэ районд дайны аюулыг гаргахгүй байх, хүчээр түрээ барих биш, гагцхүү харилцан ойлголцож, итгэлцэж, аливаа маргаантай асуудлыг хэлэлцээний замаар шийдвэрлэх ёстой гэж манай нам үздэг юм. Ийнхүү олон улсын харилцаанд хүч хэрэглэхээс татгалзах зарчим нь хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангах үндэс болох ёстой.

Чухамхүү энэ үзлийг үндэс болгон манай намын XVIII их хурал дээр нөхөр Ю. Цэдэнбал Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтлох, хүч үл хэрэглэх тухай Коивенц байгуулах, түүнийг хэ-

рэгжүүлэхийн тулд Ази, Номхон далайн орнуудын бага хурлыг хуралдуулах санал дэвшүүлсэн юм.

Энэ саналын гол агуулгыг нөхөр Ю. Цэдэнбал: «НҮБ-ын дүрэм, Бандунгийн тунхаглал, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад баримт бичигт тусгагдсан улс хоорондын харилцааны түгээмэл зарчмуудыг дээр дурдсан бүс нутгийн улс хоорондын харилцааны хэм хэмжээ болгон бататгахад конвенцийн гол зорилго оршино»¹ гэж тодорхойлсон билээ.

Намынхаа энэхүү санаачлагыг удирдлага болгон энэ оны зургадугаар сард хуралдсан БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулган Ази, Номхон далайн бүх орны парламентад хандаж уриалга гаргаж түүнд: «Ийм конвенц байгуулах нь түгшүүртэй байдал, мөргөлдөөний гол шалтгааныг арилгана гэдэгт бид итгэж байна»² гэж тэмдэглэв. Мөн нөхөр Ю. Цэдэнбал тухайн асуудлаархи манай засгийн газрын бодлогыг тодорхойлсон илгээлт бичгийг Ази, Номхон далайн орнуудын төрийн тэргүүн нарт явуулсан юм.

МАХН-ын энх тайванч санаачлагыг манай өмөг түшиг-ЗХУКН, нөхөр Л. И. Брежнев өндөр үнэлж талархан дэмжсэн явдал монголын ард түмний зориг эрмэлзлэлийг улам бадрааж байна. Мөн Азийн социалист орнууд, энхийг эрхэмлэгч бусад улс түмэн талархан дэмжиж байгаа нь Ази тивд итгэлцэлийг бэхжүүлэх үндэс байна гэдгийг харуулж байна.

МАХН-ын энх тайванч гадаад бодлогын илрэл болсон энэхүү саналыг хэрэгжүүлэх явдал Ази, Номхон далайн районы улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх, түүнд саад тотгор болж байгаа америкийн империализм, түүний шууд холбоотон болж хувирсан хятадын жанжлах үзэлтний эзлэн түрэмгийлэх бодлогыг илчлэн няцаахтай нягт холбоотой юм.

Ази тивийн энх амгалан байдалд ноцтой занал учруулж буй гол хүчин зүйл бол америкийн империализм, хятадын жанжлах үзэлтний цэрэг-улс төрийн хуйвалдаан мөн.

Зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг америк-хятадын харилцан зохицуулсан бодлогоор америк-хятадын харилцааны өнөөгийн шинж төрх тодорхойлогдож байна. Америкийн империализм зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг хятадын эрх баригчдын бодлогыг өлгөн авч Ази, Номхон далайн районд үзүүлэх нөлөөнийхөө хүрээг тэлэн өргөтгөхөөр махран зүтгэж байгаа нь энэ бүс районы байдлыг хурцатгаж байна. Энэ чанараараа америк-хятадын хуйвалдаан нь коммунизм, зөвлөлтийг эсэргүүцсэн империалист түрэмгий бодлогын салшгүй хэсэг болж байна.

Хятадын эрх баригчид америк хамсаатан нарынхаа техник, эдийн засгийн «тусламжинд» түшиглэж улс орныхоо нийгмийн амьдралыг цэрэгжүүлэх явцыг түргэтгэхийн зэрэгцээ армия «шинэчлэх» ажлыг шуурхайлан явуулж өөрийн хил залгаа улс гүрнүүдийн бүрэн эрх, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдалд аюул занал учруулахыг оролдож байна.

Хятадын эрх баригчид БНСВУ-ын эсрэг явуулсан түрэмгий дайнаа шатлан өргөжүүлж хоёрдахь удаагийн түрэмгийллээ үйлдэхээр завдаж бүрэн эрхт социалист Вьетнам улсын аюулгүй байдалд байнга заналхийлж байна. Тэд Кампучийн ард түмэнд түлхэгдэн унасан Полпотын цуст дэглэмийг дахин сэргээхийн тул улс төрийн талаар нэгэнт дампуурсан Н. Сианук, Кхиу Самфан, Сон Санн нарыг өөр хооронд нь эвлэрүүлэн «нэгдсэн фронт» байгуулж Кампучийн ард түмний жинхэнэ эрх ашгийг төлөөлсөн БНКАУ-ын засгийн газрын эсрэг хуйвалдаан зохиож байка.

Тэд БНАЛАУ-ын эсрэг үзэл суртлын хорлон сүйтгэх ажиллагаа явуулж Лаосын ард түмнийг сонгож авсан замаас нь салгахын тулд цэ-

¹«Үнэн» сонин, 1981. 6. 19.

²«Үнэн» сонин 1981. 6. 30.

рэг-улс төрийн даралт шахалт үзүүлсээр байна. АНУ-тай сүлбээлдэн Пакистаныг зэвсэглэж, Пакистаны газар нутгийг БНААФУ, БНЭУ-ын эсрэг явуулах түрэмгийллийн бааз болгон ашиглаж байна. Японыг милитарчилахад түлхэц өгөх, хоёрдугаар дайны үр дүнг дахин хянах гэсэн хонзогногчдын санаархлыг дэвэргэн японыг цэрэгжүүлэхгүй байх тухай үндсэн хуулийн нь заалтад өөрчлөлт оруулахад чиглэгдсэн арга заль зохиож японы милитаристуудын толгойгоо өндийлгөхөд тус дөхөм үзүүлж байна. Персийн булан, Ойрхи Дорнодыг дайны голомт болгохыг оролдож энэ район дахь америкийн түрэмгий төлөвлөгөөг талархан дэмжиж байна. Иран-иракийн мөргөлдөөнийг арабын дэвшилт орнуудын байр суурийг сулруулах аятай нөхцөл гэж үзэж байна.

Бээжингийн удирдлага америкийн империализм, НАТО зэрэг цэргийн харгис эвслийн тал бүрийн дэмжлэг туслалцааг авч эзлэн түрэмгийлэх санаархлаа хэрэгжүүлэхийн тулд хятадын ард түмний үндэсний эрх ашгийг ч таягдан хаяхаас татгалзахгүй болжээ. Тайванийг нэгтгэх, Гоминданы намтай гуравдахь «нэгдэл» гэгчийг бий болгох тухай хятадын эрх баригчдын дэвшүүлсэн 9 зүйлт санал ий олон улсын империализмд хийсэн буулт, хятадын ард түмний үндсэн эрх ашгаас урвасан хэрэг мөн. Империализмд хязгааргүй үнэнчээ харуулахын тул хятадын ард түмний заналт дайсан Чан Кайши, Чан Цзинго нарын эх, эцгийн булшийг засварлах, Чан Кайшийн бичсэн дурсгалын үгийг сэргээхээс ч буцахгүй байна.³

Энэ бүх байдлаас үзэхэд хятадын эрх баригчид империализм харгислалын хүчийг нэгтгэх, коммунизмын эсрэг уялдуулан зохицуулсан бодлого явуулахыг санаархаж байгаа нь илт байна. «Иймээс манай нам империализм, харгис хүчнийг эсэргүүцсэн тэмцлийг хятадын эрх баригчдын их гүрний жанжлах үзлийг эсэргүүцэх тэмцэлтэй шууд холбон үзэж байна»⁴ гэж нөхөр Ю. Цэдэнбал МАХН-ын XVIII их хурал дээр тэмдэглэсэн юм.

Бээжингийн эрх баригч бүлэг ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг дайсагнах чиг бодлогоо улам шургуу үргэлжлүүлж байна.

Империалистуудаас явуулж буй зөвлөлтийг эсэргүүцэх бодлогод хятадын жанжлах үзэлтнүүд ая дуугаа нийлүүлж зөвлөлтийн эсрэг гүтгэлгийн кампанийг улам идэвхжүүлсээр байна. Тэд юуны өмнө ЗХУКН-ын XXVI их хурлаас дэвшүүлсэн энх тайвныг хамгаалахад чиглэсэн зөвлөлтийн санаачилгыг гүтгэн гүжирдэж түүнийг «Цэрэг-улс төрийн давуу тал олж авах гэсэн оролдлого», «түрэмгийллийн шинэ арга хэлбэр» гэж нэрлэн улс орныхоо дотоод, гадаадад өргөн сурталчилгаа явуулж одоогийн хүчний тэнцвэрт харьцааг империализмын талд ашигтайгаар өөрчлөх, тэдэнд цэрэг зэвсгийн давуу тал олж хүчээр түрээ барих бодлогоо хэрэгжүүлэхэд үнэн хэрэг дээрээ туслаж байна.

ЗХУ-тай сайн хөршийн харилцаа тогтоох ямар ч эрмэлзэлгүй байгаагаа хятадын болон дэлхийн олон нийтээс нуун далдлахын тулд зөвлөлт-хятадын хэвийн харилцаа сэргэж чадахгүй байгаагийн хариуцлагыг ЗХУ-д тохих гэж оролдсон хэвээр байна. Гэтэл бодит баримт хятадын эрх баригчдын энэ оролдлогыг няцааж байна.

Зөвлөлт-хятадын харилцааг хэвийн болгох зорилтын үүднээс ЗХУ жараад оноос эхлэн хятадын талд, хэд хэдэн чухал санал тавьсан нь хэн бүхэнд тодорхой юм. Тухайлбал, 1969—1970 онд хоёр тал бие биеийн эсрэг хүч хэрэглэхгүй байх үүрэг авч үүнийг улс хоорондын харилцааны баримт бичгээр батлах, 1971 онд хүч үл хэрэглэх, түүний дотор ердийн болон цөмийн зэвсэг хэрэглэхгүй байх гэрээ байгуулах, 1973 онд харил

³«Жэньминь жибао» 1981. 10. 10,

⁴Ю. Цэдэнбал, МАХН-ын XVIII их хуралд тавьсан НТХ-ны тайлан, хуудас 20.

цан үл довтлох гэрээ байгуулах, 1978 онд зөвлөлт-хятадын харилцааны асуудлыг энх тайвнаар зэрэгцэн орших зарчим дээр зохицуулах, дээд хэмжээнд уулзалт хийх, 1979 онд хоёр орны харилцааны зарчмын тухан тунхаглал боловсруулж гарын үсэг зурах зэрэг саналыг дэвшүүлсэн юм.

Хятадын эрх баригчид эдгээр саналуудыг хүлээн аваагүйгээр үл барам ЗХУ-тай 1950 онд байгуулсан найрамдал, холбоо, харилцан туслалцах тухай гэрээгээ 1979 онд өрөөсгөл цуцалсан билээ. Зөвлөлтийн саналын дагуу хоёр орны харилцааг хэвийн болгох хэлэлцээ явуулахыг зөвшөөрсөн боловч тэд зөвлөлтийн зэвсэгт хүчнийг хятадтай хил залгаа районоос дангаараа татах, БНМАУ, БНААФУ-аас зөвлөлтийн цэргийг гаргах, БНСВУ-ыг дэмжихээс татгалзахыг шаардан өөрийн эзлэн түрэмгийлэх бодлогоо ЗХУ-д тулган хүлээлгэх болзол тапж хоёр орны хооронд явагдаж эхэлсэн яриа хэлэлцээг тасалсан байна.

Хятадын эрх баригчид социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг ЗХУ-аас хөндийрүүлэх, болж өгвөл бүрмөсөн таслан авч тэднийг холбоотноо болгох оролдлого явуулсан хэвээр байна. Үүний тулд «сайн санаа гарган» улс хоорондын харилцааг хэвийн болгоход бэлэн байгаагаа амлахаас эхлэн үндсэрхэг үзлийг дэвэргэж тэднийг зөвлөлтийн эсрэг хандуулах, «зөвлөлтийн аюул» гэгч санаанаасаа зохиосон зүйлээр айлган сүрдүүлэх, хятад-зөвлөлтийн харилцааны байдал бусад оронд хамаагүй мэт ойлголт өгөх зэрэг зүсэн бүрийн арга заль хэрэглэж байна. «Бие даах» гэдэг нэрийн дор жижиг хөрөнгөтний үндсэрхэг явцуу үзлийг дэвэргэн марксист интернациональч байр сууринаас хөндийрүүлэх оролдлого бол социалист орнуудад ялгавартай хандах хятад маягийн бодлогын илрэл мөн. БНПАУ-д гарсан хямралын талаар баримталж байгаа хятадын эрх баригчдын байр суурь үүний тод нотолгоо болж байна. Тийм учраас социалист хамтын нөхөрлөлийн орнуудад ялгавартай хандах бодлого бол «зөвлөлтийн эсрэг» империалист бодлогын салшгүй хэсэг болж байна.

Социализмыг дайсагнагч хятадын эрх баригчдын стратегийн чиг шугамын бас нэг хэсэг нь БНМАУ-ын эсрэг явуулж байгаа улс төр, эдийн засаг, үзэл суртал, цэрэг дайны хорлон сүйтгэх ажиллагаа мөн.

БНМАУ-ын социалист бүтээн байгуулалтдаа олсон их амжилтыг бүдүүлгээр хараан зүхэж, дайрч давшлан, манай энэ ололт амжилтын үндэс суурь, баталгаа болсон монгол-зөвлөлтийн ард түмний бүх талын үр бүтээлт хамтын ажиллагаанд эргэлзээ төрүүлэхийг оролдох оролдлого нь ямар ч үр дүн өгөөгүй учраас маоистууд монголыг өөртөө нэгтгэх санаархлаа хэрэгжүүлэх, монгол-зөвлөлтийн ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг гутаахад чиглэгдсэн бодлогыг өөр арга тактикаар явуулж эхлэв.

Сүүлийн жилүүдэд хятадын эрх баригчид монгол-хятадын харилцааны болон монгол угсаатны түүх соёлыг «судлах» ажлыг идэвхжүүлж монголын судлалын нийгэмлэг байгуулах, тэндээс эрхлэн «эрдэм шинжилгээний» хурал хийх, түүндээ америк, япон, баруун германы эрдэмтдийг урьж оролцуулах, монголын түүх соёлын холбогдолтой хэдэн арван ном, товхимол, өгүүллүүд нийтлэх болов. Эдгээр «эрдэм шинжилгээний» ном зохиолд 1921 оноос өмнөх монгол угсаатны түүхийг бүхэлд нь хятадын түүхэнд хамруулах, манж, хятадын түрэмгийллийн эсрэг явуулсан монголын ард түмний болон үндэсний баатар, дэвшилт зүтгэлтэн нарын тэмцлийг «самуун», «гаднын түлхээсээр явуулсан хятадаас салган тусгаарлак хуйвалдаан»⁵ гэж нэрлэж байна.

1911оны Цагаагчин гахай жилийн хувьсгалын 70 жилийн ойд зориулж гаргасан «Хаант орос ба Цагаагчин гахай жилийн хувьсгал» ма-

⁵«Хаант орос Хятадыг түрэмгийлсэн түүх» 1 дэвтр, Бээжин 1978 он.

териалд манжаас тусгаарлахын төлөө явуулсан монголын ард түмний тэмцлийг үгүйсгэж «Ар монголыг Орос эзлэн авсан»⁶ гэж бичжээ. Маоист түүхчдийн нотолгоогоор бол монгол оронд үндэсний эрх чөлөөний төлөө хөдөлгөөн огт байгаагүй, БНМАУ-ын тусгаар тогтнол нь Хаант оросын азлэн түрэмгийлсний үр дагавар болж таарч байна.

Түүнчилэн феодалын үеийн монголын хаадыг «бүрэн хятадчилагдсан» хүмүүс байсан мэтээр нотлохыг оролдож үүгээрээ «монгол хэзээнээс хятадын хэсэг байсан» гэдгийг батлах, ийнхүү эртний хаадаасаа уламжлан авсан нутаг дэвсгэрийн өнгөлзөлгөндөө түүхийн үндэслэл олж авах алс хэтийн хорон санаагаа илэрхийлж байна.

Хятадын эрх баригчид монгол угсаатны төв Өвөр Монголд байгаа мэтээр бичиж монголын түүхэнд нөлөө бүхий феодал ангийн зарим төлөөлөгчдийн «дурсгалыг мөнхжүүлэх» сурталчилгааг явуулах болсон нь монголчуудын анхаарлыг хятад руу хандуулах, зөвлөлтийн эсрэг үндсэрхэх үзлийг бүрэлдүүлэн тогтоох гэсэн санаа юм.

Монголын түүхийг бүдүүлгээр гуйвуулж, монгол-зөвлөлтийн найрамдалд өө сэв суулгах хятадын эрх баригч бүлгийн бүтэлгүй санаархал бүхэлдээ социализм ба зөвлөлтийн эсрэг стратегийн бодлогын нэг хэсэг нь бөгөөд үүнийг хятад-зөвлөлтийн харилцааг цаашид байнга хурцадмал байдалд байлгах нэг шалтаг болгон ашиглах зорилт тавьж байгаагийн илрэл гэхээс өөрөөр үнэлэх аргагүй юм.

Хятадын эрх баригчид капиталист бус хөгжлийн замын манай орны туршлагыг үгүйсгэж зөвхөн хятадын маоист замаар явахыг хөгжиж байгаа орнуудад тулган хүлээлгэхийг оролдож байна. Энэ нь хэрэг дээрээ Октябрийн социалист их хувьсгалын дэлхий дахины түүхэн ач холбогдол, марксизм-ленинизмын гандан бууршгүй сургаалыг гутаах гэсэн санаархал юм.

Ийнхүү хятадын эрх баригчид олон улсын талбарт коммунизм, социализмыг эсэргүүцэх үзлийг хамгийн идэвхтэй дэмжигчийн нэг болж милитарист хэт даврүү үзлээ улс төрийн бодлого болгон бусдад тулгахыг эрмэлзэж байна. Тэдний энэ байр суурийг олон улсын империализм, юуны өмнө америкийн империализм талархан сайшааж, тэтгэн дэмжиж байна. Хятадын «шинэчлэх» бодлогод империалист гүрнүүд туслахдаа санхүүгийн багагүй хохирол үзэж байгаа боловч тэдэнд улам их мөнгө хөрөнгө өгөхөөр амлаж байгаа нь үүний тодорхой нотолгоо юм.

Олон улсын империализм хятадын жанжлах үзэлтний дайсагнагч бодлогын уршгаар дэлхий дахин, түүний дотроос Ази тивийн байдал сүүлийн үед эрс хурцдаж байгаа нь социализмын орнууд болон бусад давшилт улс түмэн, энхийг эрхэмлэгч бүх хүчний сэтгэлийг түгшээж байна.

Саяхан хуралдсан МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал дэлхийн халуун цөмийн сүйрлийг сэрэмжлэн зайлуулах, түгшүүртэй байдлын дөлийг дарах, намжмал байдлыг бэхжүүлэх ариун үйлс, түүний дотор дэлхийн хүн амын дийлэнх олонхи нь оршин суудаг Ази тивийн байдлыг эрүүлжүүлэх арга замын талаар манай улсын чин эрмэлзлэл, оруулж байгаа хувь нэмрийг тэмдэглэв. Энэ бол манай нам, засгийн газар, монголын ард түмний энх тайванч гадаад бодлогын бас нэг тод илрэл боллоо.

Америкийн өнөөгийн засаг захиргаа дэлхий дахины үйл хэрэгт АНУ-ын жанжлалыг тогтооход чиглэсэн стратегийн шинэ бодлого явуулж буйг болон тэд хятадын жанжлагчидтай сүлбээлдэн Азийн улс түмний энх тайван, аюулгүй байдалд дайсагнасан үйл явууллагаа идэвхжүүлж байгааг тус бүгд хурал тэмдэглээд «Юуны өмнө Зөвлөлт Холбоот Улс болон Азийн социалист бусад орнуудын эсрэг шууд чиглэсэн АНУ-Хя-

тад-Японы цэрэг улс төрийн гурамсан түрэмгий холбоо үнэн хэрэгтээ бүрэлдэн тогтож байна»¹ гэж дүгнэлээ.

МАХН-ын XVIII их хурлын тайлан илтгэл, сая хуралдсан III бүгд хурлын материалд Ази тивийн өнөөгийн байдалд өгсөн зарчмын дүгнэлт, манай намаас явуулах бодлогын үндсэн заалт нь манай орны Дорнодахины судлалын чиглэл, ээлжит зорилтыг тодорхойлж байна.

Дорно дахины нүүдэлчин улс түмний соёл иргэншлийн нэг чухал төв болж байсан монгол орон Дорно дахины улс түмэнтэй түүх соёлын өргөн харилцаатай хөгжиж ирсэн учраас тэр харилцааны түүхийг судлах явдал түүхийг үнэн зөв байранд нь тавих, ард түмнүүдийн хоорондын харилцан итгэлцэх явдалд тус дөхөм үзүүлэх юм.

Газар нутаг, хүн амаар төдийгүй нийгмийн хөгжлийн түвшингээр янз бүрийн хэвшилтэй Ази тивийн байдлыг судлах асуудал энэ тивийн олон улсын тавцанд эзлэх байр суурь улам өсч байгаа одоо үед онц чухал болж байна.

Маоист хагалан бутаргагчдын империалист маягийн бодлоготой холбож Хятад, Азийн орнуудын харилцааны байдлыг судлах явдал шаардлагатай юм. Хятадын эрх баригчдаас Азийн орнуудын өнгөрсөн, эдүгээгийн түүхийг гуйвуулж байгаа одоогийн нөхцөлд энэ нь бүүрч чухал гэдэг нь ойлгомжтой юм.

Монгол улс капиталист биш хөгжлийн замаар давшин хөгжиж, капиталист бус хөгжлийн тухай марксист үндэслэлийг практикт хэрэгжүүлсэн орны хувьд өөрийн хөгжлийн туршлагыг үндэснийхээ эрх чөлөөний төлөө тэмцэж байгаа Ази, Африк, Латин Америкийн улс түмэнд танилцуулах, үндэсний эрх чөлөөний төлөө хөдөлгөөн нь социалист ертөнцтэй холбоо тогтоосны үрээр сая амжилтанд хүрч болохыг монгол орны хөгжлийн туршлагаар харуулах, сурталчлах явдал бидний интернационалч үүргийн нэг мөн. «Эдийн засаг, нийгмийн дэвшилд хүрэх хамгийн бодитой арга замыг социалист орнуудын хөгжлийн туршлага, тухайлбал БНМАУ-ын капиталист бус хөгжлийн туршлага харуулж байна»⁷

Дорнодахины судлалын нэг чухал хэсэг бол хятад судлалын ажил юм.

Манай оронд шинэхэн бий болсон хятад судлалын ажил сүүлийн жилүүдэд урагштай хөгжиж байна.

«Ард түмний эсрэг, социализмын эсрэг хятадын эрх баригч бүлгийнхний чиг бодлогыг хойшид ч шийдвэртэй илчлэх»⁸ тухай намынхаа заалтыг үндэслэж хятадын эрх баригчдын явуулж байгаа, социализмыг эсэргүүцэх, зөвлөлтийг эсэргүүцэх үзэл, империализмтэй хийж байгаа хуйвалдааныг илчлэн няцаахад зохих хувь нэмэр оруулах явдал бол хятад судлалын ажлын үндсэн зорилтын нэг мөн.

Үүний тулд хятадын эзлэн түрэмгийлэх бодлогын уг үндэс, түүний уламжлал, хор нөлөө, тэр нь хятадын ард түмэн болон айл зэргэлдээ орны ард түмэнд хэрхэн тусч байгаа, империализм-хятадын хоорондын цэрэг-улс төр, эдийн засаг, үзэл суртлын ойртолт, хамтын ажиллагаа Азийн улс түмнийг эзлэн түрэмгийлэх, тэнд өөрийн ноёрхлыг тогтоох санаархал, дэлхийг хуваан эзлэх бодлогод империализм, хятадын хоорондын харилцаанд гарч байгаа болон гарч болох зөрчил, өрсөлдөөн, Азийн орнуудад балмад бодлогоо тулган хүлээлгэхийн тулд тэднийг дотроос нь хагалан бутаргах оролдлогын арга хэлбэр, түүнд хятадын цагаачдын гүйцэтгэж байгаа үүрэг, хятадын эзлэн түрэмгийлэх бодлогын арга тактикт гарч байгаа өөрчлөлт, хятадад болж байгаа хэрэг явдлын үүсэл

¹МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал дээр н. Ю. Цэдэнбалын хэлсэн үг«Үнэн», 1981 оны арван хоёрдугаар сарын 3.

⁷МАХН-ын XVIII их хурлын тайлан, хуудас 15.

⁸Мөн тэнд.

хөгжил, марксист үндэсний бодлогыг завхруулж буй байдал зэрэг асуудлыг марксизм-ленинизмын онолын үндэслэлд тулгуурлан буурь суурьтай судлах явдал шаардлагатай байна. Энэ нь маоизмын харгис бурангуй шинж төрхийг илчлэн няцаахтай холбоотой юм.

Манай намаас маоизмын эсрэг явуулж буй тэмцэл эцсийн бүлэгт хятадын ард түмэн, хятад дахь эрүүл хүчинд туслаж байгаа хэрэг. Ах дүү социалист орнуудын коммунист ажилчны намын их, бүгд хурал, социалист орнуудын марксист түүхчдээс хятадын байдалд өгч буй үнэлэлтийг хятадын эрх баригчид хүлээн авахаас татгалзаж байгаа боловч түүнийг эцсийн эцэст харгалзан үзэхээс өөр аргагүйд хүрч байгаа явдал үүнийг харуулж байна.

Монгол-хятадын харилцааны бүх үеийн түүхийг шинжлэх ухааны үндэслэлтэй, намч, ардач, ангич байр сууринаас нарийвчлан судлаж монгол-хятадын харилцааны эртний болон одоогийн түүхийг бичиж гаргах явдал нэн тулгамдсан шаардлага болж байна. Үүнд хятадын эрх баригчдын «манай орныг эзлэн түрэмгийлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийг оролдохдоо түүх, бодит үнэнийг завхруулж»⁹ байгаа болон ялангуяа 1949 оноос хойших монгол-хятадын харилцааны түүхийг бичихдээ хоёр орны харилцаа муудсан шалтгааныг «Хятадын эрх баригчид социализмын зарчмыг мушгин гуйвуулж, улс хоорондын харилцааны хэм хэмжээг балмадаар алдагдуулан, тэдгээрийг их гүрний жанжлах үзэл, айлган сүрдүүлэх, тулган шахах, бодлого, үйлдлээр»¹⁰ сольсонд оршиж байгааг үл үндэстэй, бодит баримтаар тодорхойлох нь хятадын аюулд өртөгдөж байгаа бусад улс түмэнд ч ач холбогдолтой юм.

Зөвлөлтийн «Проблемы Дальнего Востока» сэтгүүлийн энэ оны гуравдугаарт нөхөр О. Б. Борисовын бичсэн «XXVI их хурал ба хятадын түүхийн судлалын зарим асуудал» өгүүлэлд дэвшүүлсэн хятадын судлалын өнөөгийн зорилтууд нь манай хятад судлалд мөн нэгэн адил хамаарагдана.

Манай Дорнодахины судлал, ЗХУ, ах дүү социалист орнуудын Дорно дахины судлалын онол практикийн арвин баялаг туршлагаас байнга суралцан тэдэнтэй бүх талын хамтын ажиллагааг бэхжүүлсний үндсэн дээр тодорхой амжилтад хүрч чадахыг амьдрал харуулсан билээ. Тийм учраас ЗХУ, социалист бусад орны эрдэмтэдтэй хамтран маоизмын харгис мөн чанарыг илчилсэн дорвитой бүтээл туурвих, эрдэм шинжилгээний ажлын зохицуулалтыг сайжруулах, энэ үндсэн дээр эрдэм шинжилгээний ажлынхаа онол, үзэл суртлын төвшинг улам дээшлүүлэхэд бидний нэг гол зорилт оршино.

Бидний хойшлуулшгүй зорилтын нэг бол марксист-ленинист улс төрийн өндөр боловсролтой, интернационалч зарчимд үнэнч, судалж байгаа асуудлынхаа талаар гүн бат мэдлэгтэй боловсон хүчнийг бэлтгэн гаргахад оршино. Шинжлэх ухааны ажлыг цаашид улам сайжруулах тухай Намын Төв Хорооны тогтоолд заасны дагуу шинжлэх ухааны байгууллагын ажилтан нар сургалтын процесст оролцож байх нь энэ зорилтыг хэрэгжүүлэх нэг арга мөн. ЗХУ, улс орныхоо дотоодод бэлтгэн гаргасан мэргэжилтэй боловсон хүчний цаашдын өсөлт хөгжилтөд байнга анхаарч, тэдэнд өөрсдийн эрдэм мэдлэг, эрдэм шинжилгээний ажлын баялаг туршлагыг уламжлуулах явдал бол манай нэрт эрдэмтэд, ахмад үеийн нэр төрийн хэрэг юм.

МАХН-ын XVIII их хурлаас дэвшүүлсэн манай энх тайванч гадаад бодлогын чиг шугамыг улам гүнзгийрүүлсэн III бүгд хурлын заалттай холбогдуулан манай нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгүүд, ялангуяа

⁹МАХН-ын XVIII их хурлын тайлан хуудас 20

¹⁰Мөн тэнд. хуудас 13

Дорнодахины судлалын хүрээлэн өөрийн явуулж буй шинжилгээ, судалгаандаа МАХН-ын XVIII их хурал, 1981 оны III бүгд хурлын заалтыг тусгаж төвийн хэвлэлүүд болон «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүлээр дамжуулан дотоод, гадаадын уншигчдад манай энх тайванч гадаад бодлогыг өргөн сурталчлах явдал чухал шаардлагатай байна. Энэ нь хөрөнгөтний харгис үзэл суртал хятадын одоогийн эрх баригчдын маоист бодлогыг илчлэн няцаах талаар манай намаас явуулж буй тэмцлийн салшгүй хэсэг болохын зэрэгцээ залуу үеийг нам, ард түмэндээ хайртай, эх оронч интернационалч үзлээр хүмүүжүүлэхэд чухал хувь нэмэр үзүүлэх болно.

XVIII СЪЕЗД МНРП И ВОПРОСЫ РАЗВИТИЯ ВОСТОКОВЕДЕНИЯ

(Резюме)

Р. Рэнцэн

XVIII съезд МНРП особо подчеркнул необходимость создания благоприятных внешних условий для успешного строительства социализма в МНР. Партия и правительство нашей страны совместно с другими социалистическими странами последовательно проводит миролюбивую внешнюю политику по ослаблению напряженности в различных регионах мира, претворения в жизнь разрядки и обуздания гонки вооружений. Этим целям подчинено выдвинутое на XVIII съезде МНРП предложение МНР о заключении Конвенции о взаимном ненападении и неприменении силы в отношениях между государствами Азии и Тихого океана.

Несмотря на мирные инициативы социалистических стран силы реакции в ущерб интересам народов мира все больше раздувают опасность возникновения новой войны, и это нагнетание напряженности находит полную поддержку у нынешнего пекинского руководства.

III Пленум ЦК МНРП, состоявшийся в декабре 1981 года, еще раз указал, что обострение международной обстановки в Азии исходит от американского империализма, предпринимающего активные шаги для усиления своего влияния на земном континенте. На Пленуме было особо выделено, что создание военно-политического тройственного союза США-Китай-Япония прямо направлено прежде всего против Советского Союза и социалистических стран Азии.

Сближение с силами империализма, дифференцированный подход к социалистическим странам, замыслы о присоединении МНР к Китаю являются составной частью политики антисоветизма, проводимой Пекином.

Принципиальная оценка состояния международных отношений в Азии, данная XVIII съездом МНРП и III Пленумом ЦК МНРП, определяет очередные задачи и направления развития востоковедения в нашей стране, суть которого, в частности, сводится к следующему:

- изучению культурных и исторических связей народов Востока;
- ознакомлению борющихся народов Азии, Африки и Латинской Америки с историческим опытом некапиталистического пути развития МНР;

- разоблачению антисоциалистической деятельности китайского руководства;
- необходимости создать фундаментальный труд о развитии монголо-китайских отношений на всех этапах:
- совершенствованию методов сотрудничества с учеными-востоковедами социалистических стран;
- подготовке квалифицированных научных кадров в данной области общественных наук.